



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН байдал

Monthly bulletin of **STATISTICS**

2020/05



Activ
Go to ?

АГУУЛГА



Бүртгэлтэй ажилгүйчүүд



Эрүүл мэнд



Банк



Төсөв



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ



Хөдөө аж ахуй



Аж үйлдвэр



Цахилгаан холбоо

Аргачлалын тайлбар Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гаргаж авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөх болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Мөнгө, банк

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгийг банкнаас гадуурх мөнгө болон касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Бага мөнгө /M1/-ийг банкнаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Төгрөгийн харилцах дансан дахь мөнгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Бараг мөнгийг төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

Төгрөг болон валютын хадгаламжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Валютын харилцахыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Мөнгөний нийлүүлэлт /M2/-ийг банкнаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тооцно. Өөрөөр хэлбэл бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Хэвийн зээл гэж төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээлийг зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлно.

Чанаргүй зээлийг хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тооцож гаргана.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нэг өрхөөс бус нийт өрхөөр тооцогдсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашигладаг.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж байна.

$$I_{ct}^L = \frac{\sum P_{it} Q_{io}}{\sum P_{io} Q_{io}}$$

I_{ct}^L -t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t –тайлант үе, 0 – суурь үе,

P_{it} -'i' барааны тайлант үеийн үнэ,

P_{io} -'i' барааны суурь үеийн үнэ,

Q_{io} -'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

\sum -нийлбэрийн тэмдэг

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний сагсан дахь нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), хэрэглээний зардлын жинг шинэчилж, 2012 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн индексийг тооцоход ашиглаж байна.

Хөдөө аж ахуйн гол нэрийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээг сум, аймгийн үнэ цуглуулах нэгжүүдээс сар бүр авч, сарын дундаж үнийг тооцож байна.

Хөдөө аж ахуй

Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ. Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, гол мөрөн, худаг хавцалд унах зэрэг хариулга маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

Нэгдсэн төсөв

Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээг Монгол улсын Сангийн сайдын 2015 оны 1 сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар төсвийн ангиллаар 2015 оны 1 дүгээр сараас эхлэн гаргаж байна. Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлага нь улсын төвлөрсөн төсвөөс шууд санхүүждэг төсвийн байгууллагуудын болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтсээс сар бүр гаргаж статистикийн хэлтэст ирүүлдэг.

Орон нутгийн төсөв нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ. Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар, татварын орлогын төрлүүдээр харууллаа. Төвлөрсөн төсвийн орлого нь улсын төсвийн санхүүжилт, татварын бус орлогоос бүрдэнэ.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт нийт үйлдвэрлэл нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуй нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, үйлдвэрлэлийн биет хэмжээний индексийг тооцно.

Хөдөлмөр

Эдийн засгийн идэвхитэй хүн ам(ажиллах хүч)-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч , нийлүүлэхэд бэлэн байгаа ажилдгүй иргэдийг хамруулна.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2020 оны 05 дугаар сарын байдал)

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН

Аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газарт ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 5 дугаар сарын эцэст 994 байгаа нь өмнөх оны мөн үеэс 163 (19.6%) хүнээр, өмнөх сараас 93 (10.3%) хүнээр өсч, бүртгэлтэй ажилгүй иргэдийн 475 (47.8%) эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд ажилгүй иргэдийн 21 (2.1%) хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа ба 13 (61.9%) эмэгтэйчүүд байна.

2020 оны 5 дугаар сард ажилгүй 163 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 29 иргэн ажилд зуулчлагдан орж, 41 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн хувьд ажил хайж буй шалтгаанаар нь задлан харахад хамгийн өндөр хувийг цалин орлого хүрэлцэхгүй иргэд 21.5 хувь нь, хамгийн бага хувийг хорих газраас суллагдсан иргэд буюу 0.6 хувь нь эзэлж байна.


Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 55.7 хувийг бүрэн дунд, 22.6 хувийг дипломын болон бакалаврын дээд, 8.8 хувийг техник мэргэжлийн, 6.0 хувийг суурь, 4.3 хувийг тусгай мэргэжлийн дунд, 1.4 хувийг бага, 1.2 хувийг ямар ч боловсролгүй иргэд эзэлж байна.

Мөн аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 51.6 хувийг 15-34 насны залуучууд, 43.2 хувийг 35-54 насныхан, 5.2 хувийг 55 дээш насныхан тус тус эзэлж байна.




ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 5 сарын байдлаар 572 эх амаржиж, 577 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 8 (1.4%)-аар, амьд төрсөн хүүхэд 5 (0.9%)-аар тус тус өссөн байна. Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдэл 2020 оны эхний 5 сард 7 болж, өмнөх оны мөн үеэс 7 (50.0%)-аар буурсан байна.



Халдварт өвчнөөр өвчлөгчид 130 болж, өмнөх оны мөн үеэс 40 (23.5%)-аар буурахад гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчид 9 (81.8%)-аар, салхинцэцэг өвчнөөр өвчлөгчид 71 (93.4%)-аар, заг хүйтэн өвчнөөр өвчлөгчид 8 (34.8%)-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин трихомониаз өвчнөөр өвчлөгчид 2 (1 дахин), тэмбүү 22 (71.0%) сүрьеэ өвчнөөр өвчлөгчид 6 (50.0%) өссөн байна.




Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 5 сарын байдлаар нас баралтын 110 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 31 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Нас барсан хүний 55.5 хувь нь эрэгтэй, 44.5 хувь нь эмэгтэй байна. Нийт нас баралтын 22.7 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд 20.0 хувь нь хоног болоогүй байна.

Нийт нас баралтын 34 буюу 30.9 хувийг хорт хавдрын, 18 буюу 16.4 хувь нь осол гэмтлийн шалтгаантай байна. 2020 оны эхний 5 сарын байдлаар нийт 109 538 үзлэг хийгдсэний 22.8 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэг, 51.8 хувь нь өвчний учир амбулаторит, 9.8 хувь нь идэвхтэй хяналт, 13.0 хувь нь гэрийн идэвхтэй үзлэг, 2.7 хувь нь гэрийн дуудлагын үзлэг тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 5 сарын байдлаар эмнэлэгт 6002 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлж, 43721 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.3 байна.

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид жил бүрийн 5 сарын байдлаар



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн сангаас 2020 оны 5 дугаар сард 24.1 мянган иргэнд 3 тэрбум 527.1 сая төгрөг олгожээ. Үүнээс нийгмийн халамжийн үйлчилгээний зардалд 2 тэрбум 263.0, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж 19.4, алдарт эхийн одонгийн тусламжид 644.9, хүнс тэжээлд 140.3, алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламжид 24.6, насны хишиг 225.7, цалинтай ээж 131.2 сая, өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж 49.5, ОНОТХҮйлчилгээ 28.5 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын шимтгэлээр 7 тэрбум 25.2 сая төгрөг, тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн санхүүжилтээр 11 тэрбум 420.7 сая төгрөг, бүгд 18 тэрбум 445.9 сая төгрөгийн эх үүсврийн орлого төвлөрүүлж, тэтгэврийн даатгалын сангаас 8.3 мянган хүнд 14 тэрбум 11.6 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 664 даатгуулагчид 598.8 сая, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 21 даатгуулагчидад 39.8 сая, ажилгүйдлийн тэтгэмжид бүртгүүлсэн 54 иргэнд 124.4 сая төгрөгийн зардлыг тус тус бүрэн олгожээ.

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2020 оны 05 сард өмнөх оны мөн үеэс 1.7 хувь, жилийн эцсээс 2.0 хувиар өссөн, өмнөх сараас 1.0 хувиар өссөн байна.

Ерөнхий индекс 2020 оны 05 сард өмнөх сараас 1.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, ус бүлгийн индекс 4.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Банк

Зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 05 сард 124.2 тэрбум төгрөг байгаа ба 0.9 хувийг чанаргүй зээл эзэлж байна.


Харицахын үлдэгдэл 2020 оны 05 сард 25.8 тэрбум төгрөг байгаа ба үүнээс иргэдийн харилцахын үлдэгдэл 18.4 тэрбум буюу 71.1 хувийг эзэлж байна.

Нийт хадгаламжийн үлдэгдэл 2020 оны 05 сард 96.9 тэрбум төгрөгт хүрчээ.

ТӨСВИЙН ОРЛОГО

Орон нутгийн төсөвт нийт 2.3 тэрбум төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 87.8 хувиар, үүнээс улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг 8.6 тэрбум төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 15.8 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн санд 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан бол, татварын орлого 2 тэрбум төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 93.2 хувиар, татварын бус орлого 301.9 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 71.6 хувиар тус тус биелүүлсэн байна. Аймгийн төсөвт байгууллагууд 690.9 мянган төгрөгийн авлагатай, 202.9 сая төгрөгийн өглөгтэй байна.


ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ЭЗЛЭХ ХУВЬ 2020 оны V сард



ТӨСВИЙН ЗАРЛАГА

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтийн гүйцтгэл 42.3 тэрбум төгрөгт хүрч жилийн төлөвлөгөөний 77.4 хувийг санхүүжүүлэв. Үүнд цалин хөлс, нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 95.9, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 94.4, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 82.4, нормативт зардал 79.1, эд хогшил, урсгал засварын зардал 74.5, томилолт, зочны зардлын 98.1, хөрөнгийн зардлын 23.8 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.


ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА ХУВИАР




АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны 5 дугаар сарын байдлаар 6 тэрбум 126.1 сая төгрөгт хүрчээ. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 81.0 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж үйлдвэрлэл, 6.0 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 18.0 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар тус тус эзэлж байна. Нийт 6 тэрбум 510.9 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулсан байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, 5 сар, сая төгрөг



Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл салбараар, 5 сар, хувиар




- Уул уурхай, олборлох аж үйлдвэр
- Боловсруулах аж үйлдвэр
- Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Аймгийн хэмжээнд 2020 оны 5 дугаар сарын байдлаар нийт төллөх насны 1524.9 мянган хээлтэгч малын 1223.8 мянга буюу 80.3 хувь нь төллөсөн байна. Эм ямааны 79.6 хувь, эм хонины 85.7 хувь, гүүний 62.2 хувь, үнээний 32.2 ингэний 46.1 хувь нь төллөжээ. Гарсан төлийн 99.1 хувь буюу 1068.7 мянган төл бойжиж байна.

Том малын зүй бусын хорогдол 2020 оны 5 дугаар сард аймгийн хэмжээнд 10034 толгой болж, өмнөх оны мөн үетэй харьцуулвал 23940 толгой буюу 3.4 дахин буурсан байна. Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл, адуу 564, үхэр 473, тэмээ 37, хонь 2875, ямаа 6085 байна. Нийт хорогдлын 28.6 хувийг хонь, 60.6 хувийг ямаа эзэлж байна.




ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ


Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгаагаар 2020 оны 5 дугаар сард аймгийн төв буюу Есөнбулаг суманд ноолуур 52.5 мянган төгрөг, тэмээний шир 15.0 манган төгрөг, адууны шир 3.5 манган төгрөг, үхрийн шир 2.0-3.0 манган төгрөг, хонины арьс 500 төгрөг, ямааны ноолууртай арьс 15.0 мянган төгрөгийн үнэтэй байна.

Говь-Алтай аймгийн 2020 оны V-VI сарын цаг агаарын урьдчилсан төлөв


Долдугаар сард. Сарын дундаж агаарын температур ОЖД-аар Говь-Алтайн өмнөд хэсгээр 22-28°C, бусад нутгаар 16-22°C дулаан байдаг байна. 7 дугаар сарын агаарын температур ОЖД-ийн орчим байх төлөвтэй байна (**1 дүгээр зураг**).




Сарын нийлбэр хур тунадасны олон жилийн дунджаар Говь-Алтайн өмнөд хэсгээр 10-40 мм, бусад нутгаар 40-80 мм хүртэл бороо ордог байна. 7 дугаар сарын нийлбэр хур тунадас нийт нутгаар ОЖД-ийн орчим байх төлөвтэй байна (**2 дугаар зураг**).



Наймдугаар сард Сарын дундаж агаарын температур ОЖД-аар Говь-Алтайн өмнөд хэсгээр 18-26⁰С, бусад нутгаар 12-18⁰С дулаан байдаг байна. 8 дугаар сарын агаарын температур нийт нутгаар ОЖД-аас дулаан байх төлөвтэй байна (**3 дугаар зураг**).



Сарын нийлбэр хур тунадас ОЖД-аар Говь-Алтайн өмнөд хэсгээр 10-40 мм, бусад нутгаар 40-70 мм ордог байна. 8 дугаар сарын нийлбэр хур тунадас нийт нутгаар ОЖД-ийн орчим байх төлөвтэй байна (**4 дүгээр зураг**).



Есдүгээр сард. Сарын дундаж агаарын температур Говь-Алтайн өмнөд хэсгээр 14-20⁰С, бусад нутгаар 6-14⁰С дулаан байдаг байна.9 дүгээр сарын агаарын температур нийт нутгаар ОЖД-ийн орчим байх төлөвтэй байна (**5 дугаар зураг**).

Эх үүсвэр: Говь-Алтай УЦУОШТ-ийн УМХ Утас: 70483093

**ХӨДӨЛМӨР
LABOUR**

**БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, тайлант хугацааны эцэст
NUMBER OF REGISTERED UNEMPLOYED, at the end of period**

Боловсролын түвшинээр	By educational level	2016.XII	2017.XII	2018.XII	2019.XII	5-сар In May	
						2019	2020
Бүгд	Total	786	796	919	964	831	994
Үүнээс: эмэгтэй	of which:female	435	430	462	514	435	475
Дээд боловсролтой	Higher education	265	280	226	229	243	224
Тусгай дунд боловсролтой	Specialized secondary education	35	49	46	56	26	43
Мэргэжлийн анхан шатны	Professional technical and vocational training workers	70	66	72	81	79	87
Бүрэн дунд	Upper secondary school	341	331	475	499	402	552
Суурь	Compulsory secondary school	42	41	59	59	47	59
Бага	Primary school	28	27	23	21	20	14
Боловсролгүй	Uneducated persons	5	2	18	19	14	15

**АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, насны бүлгээр, 2020 оны 5 сарын эцэст
NUMBER OF UNEMPLOYED, by age group, at the end of may 2020**

Үүнээс: насны бүлгээр of which:by age group

Сар Months	Бүгд Total	Үүнээс: эмэгтэй female	15-24	25-34	35-44	45-59	55-59	60+
			Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female
I	727	353	194	251	149	94	31	8
II	835	412	185	300	191	109	38	12
III	850	397	158	296	214	130	38	12
IV	901	428	174	304	230	143	35	15
V	994	475	188	325	266	163	35	17

2020 ОНЫ 5 САРД АЖИЛГҮЙЧҮҮДЭЭС ТАЙЛАНТ САРД АЖИЛД ОРСОН ХҮН
NUMBER OF UNEMPLOYED ENTERED INTO WORK, in the 5 months of 2020

Сар Month	Бүгд Total	Төрийн өмчит үйлдвэрийн газарт	Төрийн төсөвт байгууллагад Government organization	Компани Company	Хоршоо Cooperative	Бусад Other
I	99		93	5		1
II	11		8	3		
III	35		23	9		3
IV	98	2	32	62		2
V	29		6	12		11

АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, СУМААР
NUMBER OF UNEMPLOYED, by som

Сум	Sum	Ажилгүйчүүдийн тоо Number of unemployed						
		2016.XII	2017.XII	2018.XII	2019.XII	5-р сар		
						May		
						2019	2020	2020% 2019
Есөнбулаг	Yesunbulag	326	353	487	453	403	541	134.2
Алтай	Altai	10	27	17	30	11	20	181.8
Баян-Уул	Bayan-Uul	40	28	30	35	30	43	143.3
Бигэр	Biger	35	24	29	38	30	21	70.0
Бугат	Bugat	19	31	30	28	22	16	72.7
Дарив	Darib	17	12	54	40	66	28	42.4
Дэлгэр	Delger	44	75	24	41	21	32	152.4
Жаргалан	Jargalan	11	6	11	12	8	8	100.0
Тайшир	Taishir	15	16	3	15	4	19	475.0
Тонхил	Tonhil	20	11	30	30	18	44	244.4
Төгрөг	Tugrug	21	16	21	17	17	11	64.7
Халиун	Haliun	25	30	25	27	17	24	141.2
Хөхморьт	Huhmorit	34	16	12	34	8	23	287.5
Цогт	Tsogt	61	63	38	53	34	33	97.1
Цээл	Tseel	15	16	33	30	71	52	73.2
Чандмана	Chandmana	34	45	42	42	47	54	114.9
Шарга	Sharga	34	12	18	15	14	10	71.4
Эрдэнэ	Erdene	25	15	15	24	10	15	150.0
Бусад аймгууд болон УБ-т бүртгэлтэй	Other	-	-					
ДҮН	TOTAL	786	796	919	964	831	994	119.6

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2020 оны 05 сард өмнөх оны мөн үеэс 1.7 хувь, жилийн эцсээс 2.0 хувиар өссөн, өмнөх сараас 1.0 хувиар өссөн байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр, 2015=100%

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2020-05	2020-05	2020-05
		2019-05	2019-12	2020-04
Ерөнхий индекс	100.0	101.7	102.0	101.0
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	95.9	109.9	104.1
Согтууруулах ундаа, тамхи	3.2	102.1	101.4	100.2
Хувцас, бөс бараа, гутал	16.1	104.3	101.3	100.3
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	106.4	100.1	100.1
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	102.7	100.3	100.6
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	107.0	104.1	100.0
Тээвэр	12.2	94.5	95.8	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	99.6	100.1	100.1
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	99.1	100.0	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	112.7	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	107.7	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	101.9	100.3	100.4

Ерөнхий индекс 2020 оны 05 сард өмнөх сараас 1.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, ус бүлгийн индекс 4.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Банк

Зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 05 сард 124.2 тэрбум төгрөг байгаа ба 0.9 хувийг чанаргүй зээл эзэлж байна.

Харицахын үлдэгдэл 2020 оны 05 сард 25.8 тэрбум төгрөг байгаа ба үүнээс иргэдийн харилцахын үлдэгдэл 18.4 тэрбум буюу 71.1 хувийг эзэлж байна.

Нийт хадгаламжийн үлдэгдэл 2020 оны 05 сард 96.9 тэрбум төгрөгт хүрчээ.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ БАНКНЫ САЛБАРЫН МЭДЭЭ

(Сая төгрөг, тоогоор)

Үзүүлэлт		Үлдэгдэл
Зээл	Нийт зээлийн үлдэгдэл	124,239.1
	Үүнээс: <i>Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл</i>	936.4
	<i>Чанаргүй зээлийн үлдэгдэл</i>	1,116.3
Татан төвлөрүүлсэн хөрөнгө	Нийт харилцахын үлдэгдэл	25,831.1
	Үүнээс: <i>Иргэдийн харилцахын үлдэгдэл</i>	18,353.4
	Нийт хадгаламжийн үлдэгдэл	96,906.7
	<i>Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл</i>	95,734.5
	Үүнээс: <i>Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл</i>	23,278.3
	<i>Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл</i>	73,628.4
Тоон мэдээлэл	Нийт банкны салбар, нэгжийн тоо	45
	Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо	193
	Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор)	24159
	Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	110806
	Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	52744
	Нийт АТМ-ны тоо	22
	Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо	46433

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

мян.мөг thous.tug

ОРЛОГЫН ТӨРӨЛ	INCOME TYPE	Төлөвлөгөө Project	* Гүйцэтгэл Performance	Хувь Rate
НИЙТ ОРЛОГО		28836720.6	28646526.7	99.3
УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОСОН				
САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ		8553284.7	8553284.7	100.0
ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ		15760635.6	15760635.6	100.0
ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН		1474396.4	1474396.4	100.0
ШИЛЖЭЭГҮЙ ҮЛДЭГДЭЛ		0.0	0.0	0.0
ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО		2670053.9	2344616.0	87.8
1. ТАТВАРЫН ОРЛОГО		2177357.1	2030132.8	93.2
1.1 Орлогын албан татвар		1494948.5	1728121.2	115.6
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар		1744948.5	2112773.2	121.1
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого		1348662.5	1608872.6	119.3
Үйл ажиллагааны орлого		57620.0	63892.2	110.9
Хөрөнгийн орлого		311056.0	390180.6	125.4
Хөрөнгө борлуулсны орлого		0.0	21156.4	0.0
Шууд бус орлого		27610.0	28671.4	103.8
1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-250000.0	-384652.0	153.9
1.2 Хөрөнгийн албан татвар		107338.0	86287.9	80.4
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		61296.4	35225.9	57.5
Галт зэвсгийн албан татвар		6235.0	3054.4	49.0
татвар		39806.6	48007.6	120.6
Малд ногдуулах албан татвар		0.0	0.0	0.0
1.3 Бусад татвар, төлбөр, хураамж		228741.8	215723.7	94.3
1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж		92256.2	96233.6	104.3
Улсын тэмдэгтийн хураамж		48193.2	53410.3	110.8
Улсын тэмдэгтийн хураамжийн буцаан олголт		-5000.0		0.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр		50.0	1291.4	2582.8
Хог хаягдлын хураамжийн төлбөр		49013.0	41531.9	84.7
1.3.2 Газрын төлбөр		92897.6	70101.2	75.5
Үүнээс: Газрын төлбөр		92897.6	38460.0	41.4
Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт		0.0	31641.2	0.0
1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр		43550.0	48675.6	111.8
Үүнээс: Ойн нөөц ашигласны төлбөр		0.0	0.0	0.0
Ан, амьтны нөөц ашигласны төлбөр		0.0	0.0	0.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр		43550.0	48675.6	111.8
Байгалийн ургамал ашигласны төлбөр		0.0	0.0	0.0
1.3.4 Бусад татвар		38.0	713.3	1877.1
2. Татварын бус орлого		421545.7	301893.1	71.6
Хүү, торгуулийн орлого		409869.0	252822.8	61.7
Төсвийн байгууллагын өөрийн орлого		0.0	0.0	0.0
Түрээсийн орлого		1676.7	1931.4	115.2
Бусад орлого		10000.0	47138.9	0.0
3. Хөрөнгийн орлого		0.0	12590.1	0.0
Өмч хувьчлалын орлого		0.0	12590.1	0.0
УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО		378350.0	513594.0	135.7
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар		19800.0	43587.5	220.1
НӨАТатвар		337500.0	453883.7	134.5
Онцгой албан татвар		6100.0	6200.0	101.6
Агаарын бохирдлын төлбөр		9380.0	3891.7	41.5
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр		5400.0	6031.1	111.7
Ус бохирдуулсны төлбөр		170.0	0.0	0.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ сумаар, 5 сар
PERFORMANCE REVENUE soums, 5 month

мян.төр thous.tug

№	Сум	Soum	Нийт орлого	Gross income	
			Төлөвлөгөө Project	* Гүйцэтгэл Performance	Хувь Rate
1	Есөнбулаг	Yesunbulag	399,000.0	411,957.1	103.2
2	Алтай	Altai	16,460.0	27,380.4	166.3
3	Баян-Уул	Bayn-Uul	19,500.0	30,395.9	155.9
4	Бигэр	Biger	17,337.0	20,900.6	120.6
5	Бугат	Bugat	19,000.0	39,407.4	207.4
6	Дарив	Dariv	17,445.0	24,181.7	138.6
7	Дэлгэр	Delger	13,180.0	17,056.6	129.4
8	Жаргалан	Jargalan	14,626.7	18,096.7	123.7
9	Тайшир	Taishir	6,505.0	21,165.5	325.4
10	Тонхил	Tonhil	32,800.0	43,289.5	132.0
11	Төгрөг	Tugrug	25,990.0	31,673.8	121.9
12	Халиун	Khaliun	7,884.0	19,908.6	252.5
13	Хөхморьт	Khukhmorit	12,315.0	21,855.7	177.5
14	Цогт	Tsogt	15,100.0	33,048.5	218.9
15	Цээл	Tseel	26,592.0	59,908.5	225.3
16	Чандмань	Chandmani	20,715.5	25,941.7	125.2
17	Шарга	Sharga	12,850.0	18,504.2	144.0
18	Эрдэнэ	Erdene	17,336.0	18,814.2	108.5
19	Баянтоорой тосгон	Bayntooroi	6,000.0	6,370.4	106.2
20	Гуулин тосгон	Guulin	5,780.8	4,823.5	83.4
21	Татварын хэлтэс	Straight communicant	1,963,636.9	2,368,059.7	120.6
	Дүн		2,670,053.9	3,262,740.2	122.2

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА 5 сар
EXPENDITURE OF PROVINCIAL GOVERNMENT 5 month

/мян.мөг, thous.tug/

Төрөл type	Төсөв Plan	* Гүйцэтгэл Performance	Хувь Rate
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	54,679,571.3	42,318,869.2	77.4
НИЙТ ЗАРЛАГА	53,349,070.3	42,243,029.9	79.2
УРСГАЛ ЗАРДАЛ	49,966,773.9	41,438,799.4	82.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,963,760.7	22,723,746.8	91.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,127,751.9	15,467,255.3	95.9
Үндсэн цалин	13,238,183.3	12,734,970.1	96.2
Нэмэгдэл	724,536.0	712,079.5	98.3
Унаа хоолны хөнгөлөлт	137,390.5	107,993.4	78.6
Урамшуулал	1,004,038.5	938,046.8	93.4
Гэрээт ажлын хөлс	1,023,603.6	974,165.5	95.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,055,621.3	1,940,924.6	94.4
Тэтгэврийн даатгал	1,532,456.8	1,443,106.6	94.2
Тэтгэмжийн даатгал	47,491.5	54,183.1	114.1
ҮОМШӨ-ний даатгал	127,681.8	118,839.0	93.1
Ажилгүйдлийн даатгал	38,446.5	33,755.8	87.8
Эрүүл мэндийн даатгал	309,544.7	291,040.1	94.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,123,439.8	2,572,725.8	82.4
Гэрэл, цахилгаан	235,343.0	149,115.9	63.4
Түлш, халаалт	2,775,163.5	2,364,748.1	85.2
Цэвэр, бохир ус	112,933.3	58,861.8	52.1
Хангамж, бараа материалын зардал	874,531.3	531,354.9	0.0
Бичиг хэрэг	200,648.8	59,997.5	29.9
Тээвэр, шатахуун	454,948.4	335,176.2	73.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	69,301.3	43,978.3	63.5
Ном, хэвлэл	35,882.0	16,252.7	45.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	35,607.5	16,943.8	47.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	78,143.3	59,006.5	75.5
Нормативт зардал	383,892.3	303,674.4	79.1
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,363.0	33,800.9	65.8
Хоол, хүнс	222,438.7	204,060.5	91.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	110,090.6	65,813.0	59.8
Эд хогшил, урсгал засварын зардал	440,669.3	328,426.1	74.5
Багаж, техник, хэрэгсэл	297,714.2	194,451.2	65.3
Тавилга	8,390.5	8,234.9	98.1
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,725.0	4,819.1	41.1
Урсгал засвар	122,839.6	120,920.9	98.4
Томилолт, зочны зардал	56,498.4	55,424.3	98.1
Дотоод албан томилолт	56,498.4	55,424.3	98.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	1,151,785.0	918,724.3	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	1,022,456.3	847,663.0	82.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	56,200.6	38,621.3	68.7
Даатгалын үйлчилгээ	24,171.4	17,559.0	72.6
Тээврийн хэрэгслийн татвар	7,776.0	2,578.9	33.2
Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,085.7	1,270.0	41.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,610.0	6,307.2	26.7
Газрын төлбөр	3,988.0	240.0	6.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,437.0	1,197.6	18.6

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

Үргэлжлэл
МЯН.ТӨГ, tous.tog

	Төлөвлөгөө <i>Project</i>	* Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,060.0	3,287.4	81.0
Бараа үйлчилгээний бусад зардал	749,571.4	605,237.2	80.7
Бараа үйлчилгээний бусад зардал	675,287.0	571,429.6	84.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	74,284.4	33,807.6	45.5
ТАТААС	9,583.5	6,735.2	70.3
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	9,583.5	6,735.2	70.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,993,429.7	18,708,317.4	74.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	24,580,823.8	18,480,187.9	75.2
Засгийн газрын дотоод шилжүүлэг	6,723,881.6	2,295,586.7	34.1
Бусад урсгал шилжүүлэг	17,856,942.2	16,184,601.2	90.6
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	412,605.9	228,129.5	55.3
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	81,500.0	43,800.0	53.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,917.6	58,209.9	100.5
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан ал	123,839.5	61,903.6	50.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	149,348.8	58,697.4	39.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,382,296.4	804,230.5	23.8
Бусад хөрөнгө	3,382,296.4	804,230.5	23.8
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,330,501.0	75,839.3	5.7
Эргэж төлөгдөх зээл	1,330,501.0	75,839.3	5.7
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-1,005,471.5	3,318,331.8	-330.0
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-1,005,471.5	-3,318,331.8	330.0
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-1,005,471.5	-3,318,331.8	330.0
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-1,005,471.5	3,318,331.8	0.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ сумаар, 5 сар
PERFORMANCE REVENUE soum, 5 month

мян.мөг, thous.tug

№	Сум	Soum	Орон нутаг Provincial government		
			Төсөв Plan	* Гүйцэтгэл Performance	Хувь Rate
1	Есөнбулаг	<i>Yesunbulag</i>	18614900.5	7255178.6	39.0
2	Алтай	<i>Altai</i>	3192370.5	1063067.6	33.3
3	Баян-Уул	<i>Bayn-Uul</i>	2891278.1	1045164.0	36.1
4	Бигэр	<i>Biger</i>	2535282.5	888313.2	35.0
5	Бугат	<i>Bugat</i>	3001541.1	1090815.7	36.3
6	Дарив	<i>Dariv</i>	2709674.1	1074807.0	39.7
7	Дэлгэр	<i>Delger</i>	2971420.1	1101086.7	37.1
8	Жаргалан	<i>Jargalan</i>	2600552.5	859211.8	33.0
9	Тайшир	<i>Taishir</i>	2946240.4	1000947.0	34.0
10	Тонхил	<i>Tonhil</i>	3232321.5	1026836.4	31.8
11	Төгрөг	<i>Tugrug</i>	2563431.3	891170.8	34.8
12	Халиун	<i>Khaliun</i>	2804440.3	1256363.0	44.8
13	Хөхморьт	<i>Khukhmorit</i>	2832012.9	1086537.5	38.4
14	Цогт	<i>Tsogt</i>	3111145.1	1105342.7	35.5
15	Цээл	<i>Tseel</i>	3515038.2	985362.8	28.0
16	Чандмань	<i>Chandmani</i>	2865918.0	1085848.1	37.9
17	Шарга	<i>Sharga</i>	2473337.4	889007.1	35.9
